

НҮБ-ЫН АЮУЛГҮЙН ЗӨВЛӨЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛ

Б.Билэгжаргал¹

Товч утга: НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэлийн талаарх саналууд болон шинэчлэлийн асуудлыг одоог хүртэл эцэслэн шийдвэрлээгүй байгаагийн шалтгаануудыг судалж үзлээ.

Түлхүүр үгс: НҮБ, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэл, хориг тавих эрх, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн гишүүн, НҮБ-ын 70 жилийн ой, Ерөнхий Ассамблей.

Abstract: This article deals with the proposals concerning the UN Security Council reform and tries to find out the reasons the reform issue hasn't been resolved yet.

Key words: UN, UN Security Council reform, the veto, member of the UN Security Council, the UN's 70th anniversary, General Assembly.

НҮБ нь 70 жилийн өмнө буюу дэлхийн II дайны дараа байгуулагдсан билээ. НҮБ-ын дүрэмд бидний амьдралд хоёр удаа тохиолдсон дэлхийн дайны гай гамшгаас хойч үеэ хамгаалах болно гэж заасан байдаг.² Өнөөдөр тус байгууллагад 193 улс гишүүнээр элсээд байгаа бөгөөд бүгд Ерөнхий Ассамблейд ордог юм. Харин НҮБ-ын 6 гол байгууллагын нэг нь болох Аюулгүйн Зөвлөлд 5 байнгын, 10 байнгын бус гишүүн орон багтдаг бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд өрнөж буй шинэчлэлийн талаарх асуудлын гол шалтгаануудын нэг нь болж байна.

Өнөөдөр НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл геополитикийн хувьд өнөө үеийн дэлхийн бодит байдалд нийцэхгүй байгаа гэж олон улсууд үзэж байна. Жишээлбэл Латин Америк болон Африкийн бүсүүд ямар ч төлөөлөлгүй байгаа. Тиймээс Аюулгүйн Зөвлөлд шинэчлэл хийх

1. Олон улсын харилцаа, бүс нутаг судлаач. Магистр

2. <http://www.un.org/en/sections/un-charter/preamble/index.html>

шаардлагатай хэмээн цөөнгүй улс үзэж байгаа юм. Шинэчлэлийг гишүүнчлэл, ажлын арга барил болон ил тод байдал, хориг тавих гэсэн асуудлуудтай холбож байгаа. 1993 оноос эхлэн Ерөнхий Ассамблей тус шинэчлэлийн талаар ярьж эхэлсэн бөгөөд олон төрлийн хувилбаруудыг санал болгож хэд хэдэн улсууд байнгын төлөөлөгчдийн суудалд нэрээ дэвшүүлсэн байна. Гэвч энэхүү асуудал нь тийм ч амар шийдэгдэхгүй байгаа бөгөөд өнөөг хүртэл эцсийн шийдвэр гараагүй байгаа билээ.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэлийн талаарх саналууд.

Тодорхой улсуудаас бүрдсэн багууд өөр өөр төлөвлөгөө санал болгож байна. “G4” хэмээн нэрлэгддэг бүлэгт ордог Бразил, Энэтхэг, Япон, Герман улсууд нь өөрсдийгөө хамгийн хүчтэй орнуудын тоонд оруулж Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн болохоор нэрсээ дэвшүүлсэн байна.

Өөр хэд хэдэн улсууд “Кофе клуб” гэсэн бүлэг үүсгэн шинэчлэлийн талаар өөрийн саналаа дэвшүүлсэн ба түүний дагуу Аюулгүйн Зөвлөлд тодорхой улс орнуудын оронд бүс нутгуудын төлөөлөл байх юм. Энэхүү бүлэг нь 2000 оноос эхлэн Италийн санаачилгаар дахин хүчирхэгжиж эхэлсэн бөгөөд тэднийг “Зөвшилцлийн төлөө нэгдэгсэд” хэмээн нэрлэх болжээ. Тэдний үзэж байгаагаар Европын Холбоо нь эхний боломжит нэр дэвшигч юм. Гэсэн хэдий ч энэ саналыг шүүмжлэгчид НҮБ-ын дүрэмд зааснаар зөвхөн тодорхой улсыг НҮБ-ын гишүүн хэмээн хүлээн зөвшөөрдөг бөгөөд бүс нутгуудыг хүлээн зөвшөөрдөггүй гэж хариулсан байна.

Коста-Рика, Йордан, Лихтенштейн, Сингапур болон Швейцар улсуудаас бүрдсэн “S-5” хэмээн нэрлэгддэг бүлэг нь НҮБ-ын үйл ажиллагааг илүү ил тод болгон, хориг тавих үйл ажиллагаанд шинэчлэл хийх шаардлагатай гэсэн санал гаргасан байна.

Африкийн Холбоо Аюулгүйн Зөвлөлд Африк болон Латин Америкийн улсууд байнгын суудалтай болж улмаар бүх бүс нутгууд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд төлөөлөлтэй болох ёстой гэсэн санал дэвшүүлжээ. Үүнээс гадна шинэ гишүүд бүгд хориг тавих эрхтэй болох шаардлагатай гэсэн байна.

2005 оны 3 сард тухайн үеийн НҮБ-ын ЕНБД Кофи Аннан “Загвар А”, “Загвар В” гэсэн төлөвлөгөөг дахин санал болгосон боловч аль нь

ч амжилтанд хүрээгүй юм.³

Ийнхүү энэ шинэчлэлийн асуудлыг шийдвэрлэхгүй байгаа талаар олон орны хэвлэл, телевизийн эх сурвалжууд мэдээлж байсан байна. Жишээ нь Германы “DW” агентлагийн мэдээнд НҮБ-д шинэчлэл хийх цаг нь аль хэдийнээ болсон байна гэж бичиж байжээ. Тэрбээр 5 улс л хориг тавих эрхтэй байх нь хоцрогдсон арга юм, гэвч АНУ, ИБУИНВУ, Франц, Орос болон Хятад энэ эрхээсээ сайн дураараа татгалзана гэдэгт итгэх нь бэрх юм хэмээн мэдэгдэж байсан байна.⁴

Өөр нэгэн мэдээллийн эх сурвалжид НҮБ-ын оронд өөр байгууллага байгуулах хэрэгтэй гэсэн мэдээлэл хүртэл гарчээ. Өнөөдөр маш олон ажиглагчид НҮБ-д шинэчлэл хийх боломжтой гэдэгт итгэсээр л байна. Гэвч анхнаасаа өөрчлөгдөн шинэчлэгдэх боломжгүйгээр байгуулагдсан НҮБ нь яваандаа зорилгоо биелүүлэх боломжгүй болно. Нэгэнтээ аль нэгэн улс нь тус үүргийг ганцаараа хүлээн биелүүлэх боломжгүй, бусад улсууд нь ч үүнийг хүсэхгүй, “дэлхийн төр” гэсэн санаа нь аймшигтай санагдаж байгаа учир илүү хүчтэй, үр дүнтэй байгууллага байгуулах цаг нь болсон болов уу гэж Германы “The European” сэтгүүлд өгүүлсэн байна.⁵

Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн 2015 оны 10 сарын 1-ний өдөр зохион байгуулагдсан “Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахих” сэдэвт НҮБ-ын Ерөнхий Ассамблейн өндөр хэмжээний сэдэвчилсэн хэлэлцүүлэгт оролцохдоо НҮБ-ын шинэчлэлийн талаарх Монгол улсын байр суурийг илэрхийлсэн байна. Тэрээр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 69-р чуулганы үеэр НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэлийн талаар гаргасан шийдвэрийг Монгол улс сайшааж байгааг тэмдэглэжээ. Мөн Монгол улс байнгын болон байнгын бус гишүүдийн тоог шударга, хууль ёсны журмаар нэмэгдүүлэх болон Аюулгүйн Зөвлөлийн ажлын арга барилыг сайжруулахыг дэмжиж байгаа гэсэн байна.⁶

3. <https://www.globalpolicy.org/un-reform.html>

4. <http://www.dw.com/ru>

5. <http://www.theeuropean-magazine.com/arnaud-blin--2/6205-the-future-of-international-governance>

6. https://www.un.int/mongolia/statements_speeches/statement-he-mr-purevsuren-lundeg-minister-foreign-affairs-mongolia-high-level

НҮБ-ын шинэчлэлийн талаар Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн улсуудын байр суурь.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн талаарх тус шинэчлэлүүдийг санаачилж байгаа улс орнуудаас гадна Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн орон болох 5 улс ч гэсэн байр сууриа илэрхийлж байгаа. Жишээлбэл 2013 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар ИБУИНВУ-ын шадар сайд Ник Клегг Аюулгүйн Зөвлөлд шинэчлэл оруулах шаардлагатай бөгөөд олон улс орнууд нөлөө бүхий болох нь зөв, тийм ч учраас ИБУИНВУ нь Бразил, Энэтхэг, Герман, Япон болон Африкийн улсуудыг байнгын суудалтай болгохыг дэмжиж байна гэж мэдэгджээ.⁷

БНФУ-ын Ерөнхийлөгч Франсуа Олланд Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганы үеэр тус шинэчлэлийн талаар үг хэлсэн байна. Тэрээр “Франц улс Аюулгүйн Зөвлөлийг өргөжүүлэхийн төлөө байна. Франц улс Аюулгүйн Зөвлөлд олон төрлийн төлөөлөгчид байхыг дэмжиж байна”⁸ гэж мэдэгдсэн байна.

Харин ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин НҮБ-ын 70 жилийн ойн чуулганаар дараах зүйлийг хэлсэн байна. “НҮБ нь хоцрогдсон, түүхэн зорилгоо биелүүлсэн гэсэн яриа гараад байгаа. Мэдээж дэлхий өөрчлөгдөж байгаа тиймээс НҮБ ч гэсэн энэхүү зүй ёсны шинэчлэлийг дагах ёстой. ОХУ нь өргөн хүрээний зөвшилцлийн үндсэн дээр НҮБ-ын цаашдын хөгжилтэй холбоотой энэхүү ажлыг бүх түнш улсуудтай хийхэд бэлэн байна. Гэвч НҮБ-ын нөлөө, эрх зүйн байдлыг тогтворгүй болгох гэсэн оролдогыг маш аюултай гэж үзэж байна” гэж мэдэгджээ.⁹

Тус чуулганаар АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама мөн адил тухайн асуудлын талаар байр сууриа илэрхийлсэн байна. Тэрээр хэлэхдээ “НҮБ-ын дүрэмд тусгагдсан зүйлс өнөөдөр биелэх боломжгүй, хоцрогдсон, дайны дараах үеийн хууль зүйн тогтолцоо өнөө үед тохиромжгүй гэж үзэх хүмүүс байна. Ерөнхийдөө тэд нар НҮБ-ыг байгуулсан өдрөөс өмнөх үед буюу хүн төрөлхтөний түүхэнд ихэвчлэн баримталдаг байсан дүрэм журмыг эргэн баримтлахыг санал болгож байгаа юм. Тэд нэг нь ялж нөгөө нь ялагддаг, эрх мэдэл

7. <https://www.gov.uk/government/speeches/nick-cleggs-speech-at-the-united-nations-general-assembly-2013>

8. <http://www.franceonu.org/70eme-Assemblee-generale-des-Nations-unies-le-discours-de-Francois-Hollande>

9. <http://kremlin.ru/events/president/news/50385>

бүгдийг шийддэг, хүчирхэг улс орнууд өөрөөсөө сул улсуудад бодлогоо тулгадаг, хувь хүний эрх ямар ч ач холбогдолгүй байдаг гэсэн зарчмыг дагахыг санал болгож байгаа юм.” гэж хэлсэн байна.¹⁰

Тэгвэл БНХАУ-ын дарга Си Жинпин тус чуулганаар ерөнхийдөө хөгжиж буй орнуудыг тэр дундаа Африкийн орнуудыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн¹¹ бөгөөд Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэлийн талаар тодорхой зүйл хэлээгүй байна.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэлийн асуудал одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байгаагийн шалтгаанууд.

Шинэчлэлийн асуудал 20 гаруй жилийн турш шийдвэрлэгдэхгүй байгаа нь олон шалтаантай юм.

Нэгдүгээрт: шинэчлэлийн талаар олон санал гарч байгаа. Өөр өөр улс орнууд өөр өөр бүлэг байгуулан шинэчлэлийн төлөвлөгөөгөө гаргасан ч тэдгээр нь хоорондоо зөрчилдөж байна. “G4”-д ордог Бразил, Энэтхэг, Герман, Япон улсууд нь Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдэд нэрсээ дэвшүүлсэн бол “Зөвшилцлийн төлөө нэгдэгсэд” хэмээн нэрлэгддэг бүлгийн улсууд “G4”-ийн саналыг эрс эсэргүүцэж Аюулгүйн Зөвлөлд зөвхөн байнгын бус гишүүн орнуудын суудалд шинээр гишүүн элсүүлэхийг санал болгожээ.

Хоёрдугаарт: НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн орнууд шинэчлэлийн асуудал дээр өөр өөр улсуудыг дэмжиж байна. Жишээлбэл БНФУ “G4”, Арабын нэгэн улс болон Африкийн улсуудыг¹², ОХУ Энэтхэг болон Бразилийг, АНУ Энэтхэгийг дэмжиж¹³ байна.

Гуравдугаарт: Аюулгүйн Зөвлөлийн гишүүнчлэлд өөрчлөлт оруулбал НҮБ-ын дүрэмд мөн өөрчлөлт оруулах шаардлагатай болох болно. Ямар нэгэн өөрчлөлт хийлээ гэхэд НҮБ-ын дүрмийн 18 дугаар бүлгийн 108 дугаар зүйлд заасны дагуу Ерөнхий Ассамблейн 2/3 дэмжиж бүх гишүүдийн 2/3 (Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийг оруулан) баталсан тохиолдолд хүчин төгөлдөр болдог¹⁴ байна. Ийм тохиолдолд байнгын гишүүн орнуудаас эцсийн шийдвэр

10. <https://www.whitehouse.gov/the-press-office/2015/09/28/remarks-president-obama-united-nations-general-assembly>

11. <http://www.uscnpm.org/blog/2015/09/29/xi-jinpings-first-address-to-the-united-nations/>

12. <http://www.franceonu.org/France-and-UN-Reform>

13. <http://tass.ru/politika/2254950>

14. <http://www.un.org/en/sections/un-charter/chapter-xviii/index.html>

хамаарч байгаа тул тус улсууд (ИБУИНВУ, БНФУ, АНУ, ОХУ, БНХАУ) асуудлыг өөрийнхөөрөө шийдвэрлэх бололцоотой болж байгаа юм.

Дөрөвдүгээрт: НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүн орон одоогийнхоо давуу эрхээ ялангуяа хориг тавих эрхээ бусад орнуудтай хуваалцахыг хүсэхгүй байгаа нь ойлгомжтой. Хэдийгээр 2015 оны 10 сарын 1-ний өдөр БНФУ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 5 байнгын гишүүнийг олон нийтийг хамарсан хэрцгий явдалтай холбоогүй асуудал хэлэлцэх тохиолдолд хориг тавих эрхээ хязгаарлахыг санал бологосон ч түүнийг нь 78 улс дэмжсэн байна.¹⁵ Мөн Аюулгүйн Зөвлөлийн бусад 4 байнгын гишүүн болох АНУ, БНХАУ, ОХУ болон ИБУИНВУ нар энэхүү саналыг зөвшөөрөөгүй байна. Энэ нь хориг тавих эрхтэй улс орнууд нь энэхүү давуу эрхээ алдахыг хүсэхгүй байгааг харуулж байгаа болов уу. Жишээлбэл ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин НҮБ-ын 70 жилийн ойн арга хэмжээний үеэр дараах зүйлийг хэлжээ. “Сүүлийн үед НҮБ-ыг үр ашиг багатай, зарчмын чухал шийдвэр гаргах нь эхний ээлжинд Аюулгүйн Зөвлөлийн гишүүн орнуудын хооронд эвлэршгүй зөрчил бий болоход хүргэдэг хэмээн шүүмжилж байна. Гэвч НҮБ-ын оршин тогтнож буй 70 жилийн турш санал зөрөх явдлууд үргэлж гардаг байсан ба хориг тавих эрхээ ч тухайн улсууд үргэлж эдэлдэг байсан. Энэ эрхээ АНУ ч, ИБУИНВУ ч, Франц ч, Хятад ч, ЗХУ дараа нь Орос ч гэсэн эдэлдэг байсан. Энэ байдал нь ийм олон улс орныг төлөөлсөн байгууллагын хувьд хэвийн зүйл юм. НҮБ-ыг байгуулж байхад бүх улсууд санаа нэгтэй байна гэсэн төлөвлөгөө байгаагүй. Тус байгууллагын гол агуулга нь харилцан бие биедээ буулт хийх арга замуудыг хайн боловсруулахад оршдог ба түүний хүч нь олон төрлийн санал бодлуудыг харгалзахад байдаг юм гэжээ.”¹⁶

15. <https://twitter.com/franceonu>

16. <http://kremlin.ru/events/president/news/50385>

ДҮГНЭЛТ

20 гаруй жил үргэлжилж буй Аюулгүйн Зөвлөлийн шинэ гишүүдийн талаарх асуудал одоог хүртэл шийдэгдэхгүй байсаар л байна. Олон улс орнууд саналаа илэрхийлж байгаа боловч тодорхой шийдвэрт хүрээгүй л байна. Гэвч дэлхийн улс орнууд хөгжиж олон улсын байдал жилээс жилд өөрчлөгдөж байгаа учир Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэлийн асуудлыг байнга хойшлуулах боломжгүй болно. Тиймээс НҮБ-ын энэхүү асуудал аажим аажмаар хурцадсаар шийдвэрлэх цаг нь нэг л өдөр ирэх болно. Өнөөг хүртэл эцэслэгдэн шийдвэрлэгдээгүй байгаа нь мэдээж хэд хэдэн шалтгаантай болно. Шинэчлэлийн талаар хоорондоо зөрөлдсөн саналууд гарч байгаа, Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн орнууд одооныхоо эдэлж байгаа давуу эрхээсээ шинээр байнгын гишүүнээр элсэхийг хүсч буй улсуудтай хуваалцахыг хүсэхгүй байгаа, шинэчлэл хийвэл НҮБ-ын дүрэмд өөрчлөлт оруулах шаардлага гарах гэх мэт эдгээр зүйлс багагүй саад учруулж байна. Ямартай ч шинэчлэлийн асуудал хэзээ шийдвэрлэгдэхээс үл хамааран, шинэчлэл хийгдсэн тохиолдолд ч НҮБ-ын гол зорилго болох энхийг сахиулах үүргээ биелүүлэх ажил нь алдагдах ёсгүй юм.

НОМ ЗҮЙ. ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ

1. <https://kremlin.ru>
2. <https://tass.ru>
3. <https://twitter.com>
4. <https://www.dw.com>
5. <https://www.franceonu.org>
6. <https://www.globalpolicy.org>
7. <https://www.gov.uk>
8. <https://www.theeuropean-magazine.com>
9. <https://www.un.int>
10. <https://www.un.org>
11. <https://www.uscnpm.org>
12. <https://www.whitehouse.gov>